



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 70-36-30-40, Факс: (976) 70-36-30-40
E-mail: Selenge@audit.gov.mn

2016.12.28 № 275
танай _____-ны № _____-т

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2016 оны ээлжит сонгуулийн зардлын дүн,
хандивын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-т зааснаар сумдын сонгуулийн хорооноос хүлээн авч хянан, сонгуулийн зардлын дүн, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасны дагуу мэдээлж байна.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд 2 нам, 840 нэр дэвшигч оролцсон бөгөөд холбогдох Сонгуулийн хорооноос 2 нам, 787 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн намуудаас Монгол Ардын нам нийт дүнгээр 8,5 сая төгрөгийн, Ардчилсан нам нийт дүнгээр 17,0 сая төгрөгийн орлогыг тус тус сонгуульд зориулан төвлөрүүлэн зарцуулжээ.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 321,5 сая төгрөг төвлөрсний 5,9 сая төгрөг нь хуулийн этгээдээс, 237,5 сая төгрөг нь иргэдээс өгсөн хандивын орлого бол 78,1 сая төгрөг нь нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө байна.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчид нийт 321,2 сая төгрөгийг сонгуульд зориулан зарцуулжээ.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон Монгол Ардын намд 1,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 3 иргэнээс 8,5 сая төгрөгийн, Ардчилсан намд 1 иргэнээс 1,0 сая төгрөгийн мөнгөн хандив тус тус төвлөрсөн байна.

Харин сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд 1,0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 58 иргэнээс 67,3 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА